ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 10 дугаар сарын 22
№39 (1434)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

354.	Конвенц соёрхон батлах тухай	2919
355.	Конвенц соёрхон батлах тухай	2920

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

356.	Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай Дугаар 61	2921

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

357.	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын конвенц №81 Хөдөлмөрийн хяналтын конвенц, 1947	2923
358.	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын конвенц №129 Хөдөлмөрийн хяналтын конвенц (Хөдөө аж ахуй), 1969	2936

агуулга

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (Улсын Их Хурлын 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн тогтоол)	2912
Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	2912
Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	2913
Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	2914
Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	2915
Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	2916
Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	2917

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 10 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

КОНВЕНЦ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын “Аж үйлдвэр болон худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 1947 оны 81 дүгээр конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.БЯМБАЦОГТ**



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 10 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

КОНВЕНЦ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын “Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 1969 оны 129 дүгээр конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.БЯМБАЦОГТ**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ᠎ᠤᠨ ᠬᠤᠤᠯᠢ

᠒᠐᠒᠖ ᠣᠨ᠎ᠤ ᠑ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠤᠨ ᠒ ᠡᠳᠦᠷ

ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲ᠎ᠠ

ᠬᠥᠳᠡᠯᠮᠡᠷᠢᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠤᠯᠯᠠᠭᠤᠨ ᠤ ᠡᠷᠬᠢᠮ ᠵᠦᠢᠯ ᠶᠡᠬᠡ ᠬᠥᠳᠡᠯᠮᠡᠷᠢᠶᠢᠨ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠣᠯᠪᠠᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠨᠢᠭᠡᠨᠳᠡ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠥᠳᠡᠯᠮᠡᠷᠢᠶᠢᠨ ᠶᠠᠭᠤᠮᠳᠤ ᠭᠠᠷᠭᠠᠭᠰᠠᠨ ᠬᠣᠶᠠᠷ ᠵᠢᠭᠰᠠᠭᠠᠯᠲᠠ ᠤᠨ ᠬᠤᠤᠯᠢ ᠪᠠᠲᠤᠯᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠤᠤᠯᠢ

ᠨᠢᠭᠡ ᠳᠦᠭᠡᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠄᠄ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠥᠳᠡᠯᠮᠡᠷᠢᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠤᠯᠯᠠᠭᠤᠨ ᠤ ᠡᠷᠬᠢᠮ ᠵᠦᠢᠯ ᠶᠡᠬᠡ ᠬᠥᠳᠡᠯᠮᠡᠷᠢᠶᠢᠨ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠣᠯᠪᠠᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠨᠢᠭᠡᠨᠳᠡ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠥᠳᠡᠯᠮᠡᠷᠢᠶᠢᠨ ᠶᠠᠭᠤᠮᠳᠤ ᠭᠠᠷᠭᠠᠭᠰᠠᠨ ᠬᠣᠶᠠᠷ ᠵᠢᠭᠰᠠᠭᠠᠯᠲᠠ ᠤᠨ ᠬᠤᠤᠯᠢ ᠪᠠᠲᠤᠯᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠤᠤᠯᠢ᠄᠄ ᠨᠢᠭᠡᠨᠳᠡ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠥᠳᠡᠯᠮᠡᠷᠢᠶᠢᠨ ᠶᠠᠭᠤᠮᠳᠤ ᠭᠠᠷᠭᠠᠭᠰᠠᠨ ᠬᠣᠶᠠᠷ ᠵᠢᠭᠰᠠᠭᠠᠯᠲᠠ ᠤᠨ ᠬᠤᠤᠯᠢ ᠪᠠᠲᠤᠯᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠤᠤᠯᠢ᠄᠄ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠥᠳᠡᠯᠮᠡᠷᠢᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠤᠯᠯᠠᠭᠤᠨ ᠤ ᠡᠷᠬᠢᠮ ᠵᠦᠢᠯ ᠶᠡᠬᠡ ᠬᠥᠳᠡᠯᠮᠡᠷᠢᠶᠢᠨ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠣᠯᠪᠠᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠨᠢᠭᠡᠨᠳᠡ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠥᠳᠡᠯᠮᠡᠷᠢᠶᠢᠨ ᠶᠠᠭᠤᠮᠳᠤ ᠭᠠᠷᠭᠠᠭᠰᠠᠨ ᠬᠣᠶᠠᠷ ᠵᠢᠭᠰᠠᠭᠠᠯᠲᠠ ᠤᠨ ᠬᠤᠤᠯᠢ ᠪᠠᠲᠤᠯᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠤᠤᠯᠢ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ᠎ᠤᠨ
ᠢᠬ ᠬᠤᠷᠯᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠰ.ᠪᠢᠮᠪᠠᠴᠤᠭᠲ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 10 дугаар сарын 08-ны өдөр | Дугаар 61 | Улаанбаатар хот

Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.5 дахь заалт, 27.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1/Оюунсайханы Алтангэрэл
2/Баярмагнайн Баярбаатар
3/Лхагвасүрэнгийн Соронзонболд
4/Хишигдэмбэрэлийн Тэмүүжин
5/Дамдины Цогтбаатар

2.Энэ тогтоолыг 2026 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.БЯМБАЦОГТ**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠡᠯᠡᠨ ᠳᠡᠭᠡᠭᠡᠳᠦ ᠬᠡᠪᠯᠡᠯ ᠨᠢᠭᠡᠨᠳᠡ ᠬᠡᠪᠯᠡᠭᠳᠡᠵᠤ ᠪᠠᠢᠭᠠᠭᠤᠯᠬᠤ ᠵᠠᠷᠯᠢᠭ

ᠬᠡᠪᠯᠡᠭᠳᠡᠵᠤ ᠪᠠᠢᠭᠠᠭᠤᠯᠬᠤ ᠵᠠᠷᠯᠢᠭ

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦ №81 ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТЫН КОНВЕНЦ, 1947

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ерөнхий бага хурал нь,

Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Удирдах зөвлөлөөс 1947 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Женев хотноо зарлан хуралдуулсан гучдугаар чуулганаараа,

Чуулганы хэлэлцэх хэргийн дөрөв дэх асуудал болох аж үйлдвэр, худалдаанд хөдөлмөрийн хяналтыг зохион байгуулах тухай тодорхой саналыг батлахаар шийдвэрлэж,

Эдгээр саналыг олон улсын конвенцын хэлбэрт оруулахаар тогтож,

Нэг мянга есөн зуун дөчин долоон оны долоодугаар сарын арван нэгний өдөр дараах конвенцыг Хөдөлмөрийн хяналтын 1947 оны конвенц хэмээн нэрлэхээр тогтож батлав.

I ХЭСЭГ

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР ДАХЬ ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТ

1 дүгээр зүйл

Энэхүү конвенц хүчин төгөлдөр үйлчилж буй Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн бүр аж үйлдвэрийн салбарт хөдөлмөрийн хяналтын тогтолцоог бүрдүүлж, хэвийн ажиллагааг хангана.

2 дугаар зүйл

1. Аж үйлдвэрийн салбар дахь хөдөлмөрийн хяналтын тогтолцоо нь хөдөлмөрийн байцаагчийн хэрэгжилтэд нь хяналт тавьдаг хөдөлмөрийн нөхцөл болон ажил эрхэлж байгаа ажилтны хамгаалалтай холбоотой хууль тогтоомжийн зохицуулалт үйлчлэх бүх ажлын байранд хамаарна.

2. Дотоодын хууль тогтоомжоор уул уурхай, тээврийн салбарыг бүтнээр нь, эсхүл хэсэгчлэн энэхүү конвенцын хамрах хүрээнд хамааруулахгүй байж болно.

3 дугаар зүйл

1. Хөдөлмөрийн хяналтын тогтолцооны чиг үүрэг нь:

a) Цаг, цалин хөлс, аюулгүй байдал, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүүхэд, залуучуудын хөдөлмөр эрхлэлт болон бусад холбогдох асуудлаар хөдөлмөрийн байцаагч ажилтныг ажил үүргээ гүйцэтгэж байх үед нь хамгаалах, хөдөлмөрийн нөхцөлийг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хөдөлмөрийн байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хангах;
b) Ажил олгогч, ажилтан хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд хамгийн үр дүнтэй арга замын талаар мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл хуваалцах;
c) Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжоор тусгайлан зохицуулаагүй зөрчил, дутагдлыг холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх.

2. Хөдөлмөрийн байцаагчид нэмэлт чиг үүрэг хариуцуулж болох боловч тийм чиг үүрэг нь түүний үндсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд саад учруулахгүй, ажил олгогч, ажилтантай харилцахад шаардлагатай эрх мэдэл, хараат бус, төвийг сахисан байдлыг нь алдагдуулахгүй байна.

4 дүгээр зүйл

1. Хөдөлмөрийн хяналтыг Гишүүн улсын төрийн захиргааны байгууллагын тогтолцоонд нийцүүлэн төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, хяналтад хэрэгжүүлнэ.

2. Холбооны зохион байгуулалттай улсын хувьд ***төв байгууллага*** гэдэг нь нэг бол холбооны дээд удирдлага эсхүл холбооны аль нэг захиргааны төв байгууллага байж болно.

5 дугаар зүйл

Эрх бүхий байгууллага нь:
a) хяналтын үйл ажиллагааг Засгийн газрын бусад байгууллага, ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн байгууллагатай үр дүнтэй хамтрах хөдөлмөрийн байцаагч; болон
b) ажил олгогч, ажилтан, тэдгээрийн төлөөллийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр шаардлагатай зохицуулалтыг хийнэ.

6 дугаар зүйл

Хөдөлмөрийн байцаагч нь төрийн албан хаагч байх бөгөөд тэдний эрх зүйн байдал, ажлын нөхцөл нь ажлын байрандаа тогтвортой ажиллах

байдлыг баталгаажуулж, Засгийн газар өөрчлөгдөх, эсхүл гаднын зохисгүй нөлөөнөөс хараат бус байх баталгааг бүрдүүлсэн байна.

7 дугаар зүйл

1. Хөдөлмөрийн байцаагчийг ажилд авахдаа үндэсний хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчийг сонгон шалгаруулахад баримталдаг аливаа журмын хүрээнд ажил үүргээ биелүүлэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадварыг харгалзан шалгаруулна.

2. Мэргэжлийн ур чадварыг тодорхойлох журмыг эрх бүхий байгууллага тогтооно.

3. Хөдөлмөрийн байцаагч нь албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай сургалтад хангалттай хамрагдсан байна.

8 дугаар зүйл

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс хөдөлмөрийн байцаагчаар ажиллаж болох бөгөөд шаардлагатай тохиолдолд тодорхой ажил үүргийг эрэгтэй, эмэгтэй байцаагчид тусгайлан хариуцуулж болно.

9 дүгээр зүйл

Гишүүн улс бүр ажил үүргээ гүйцэтгэж буй ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, түүнчлэн үйлдвэрлэлийн үйл явц, ашиглаж буй материал, ажлын арга барил нь ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг судлан шинжлэх зорилгоор үндэсний нөхцөлд хамгийн тохиромжтой гэж үзсэн хэлбэрээр эмнэлэг, инженерчлэл, цахилгаан, хими зэрэг салбарын зохих мэргэшил бүхий техникийн шинжээч, мэргэжилтнүүдийг хяналт шалгалтын үйл ажиллагаанд оролцуулах шаардлагатай арга хэмжээг авна.

10 дугаар зүйл

Хөдөлмөрийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дор дурдсан нөхцөлийг харгалзаж үзсэний үндсэн дээр хүрэлцэхүйц тооны хөдөлмөрийн байцаагчийг томилно:

а) Байцаагчийн хэрэгжүүлэх чиг үүргийн цар хүрээ, ач холбогдол, ялангуяа:

i. хяналт шалгалтад хамрагдах ажлын байрны тоо, төрөл, хэмжээ, байршил;

ii. тухайн ажлын байранд ажиллаж байгаа ажилтны тоо, ангилал;

iii. хэрэгжилтийг хангах хууль тогтоомжийн тоо, төвөгшил.

b) байцаагчийн үйл ажиллагаанд зориулан олгосон материаллаг нөөц бололцоо;

c) хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор байцаагч газар дээр нь заавал шалгах бодит нөхцөл байдал.

11 дүгээр зүйл

1. Эрх бүхий байгууллага нь хөдөлмөрийн байцаагчийг дор дурдсан нөхцөлөөр хангахад шаардлагатай арга хэмжээ авна:

a) үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан, бүх хүнд хүртээмжтэй ажлын байр;

b) тохиромжтой нийтийн тээврийн хэрэгсэл байхгүй тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тээврийн хэрэгсэл.

2. Эрх бүхий байгууллага нь хөдөлмөрийн байцаагчийг албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан томилолтын болон бусад зардлыг нөхөн олгох шаардлагатай арга хэмжээг авна.

12 дугаар зүйл

1. Бүрэн эрхийг нь нотлох бичиг баримт бүхий хөдөлмөрийн байцаагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

a) хяналт шалгалтад хамрагдах аливаа ажлын байранд өдөр, шөнийн аль ч цагт урьдчилан мэдэгдэлгүйгээр чөлөөтэй нэвтрэн орох;

b) хяналт шалгалтад хамрагдах үндэслэлтэй гэж үзсэн аливаа байр, байгууламжид өдрийн цагаар нэвтрэн орох;

c) хууль тогтоомж хэрэгжиж байгааг бүрэн тогтоох зорилгоор шаардлагатай гэж үзсэн аливаа үзлэг, шалгалт, туршилт, судалгааг явуулж болох бөгөөд тухайлбал,

i. хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой аливаа асуудлаар, ажил олгогч, эсхүл байгууллагын ажилтнаас гэрчийг байлцуулан, эсхүл байлцуулахгүйгээр тайлбар, мэдүүлэг авах;

ii. хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотойгоор хууль тогтоомжид заасан бүртгэл, данс тооцоо, баримт бичиг болон бусад материалыг гаргуулан авч, хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгах, тэдгээрээс хуулбарлах, хэсэгчлэн авах;

iii. хуулийн дагуу байрлуулах ёстой мэдэгдэл, мэдээллийг байрлуулахыг шаардах;

iv. шинжилгээ хийх зорилгоор ашиглаж, хэрэглэж байгаа материал, бодисоос дээж авах, хураах бөгөөд ямар зорилгоор дээж авах, эсхүл хурааж байгаа тухайгаа ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчид урьдчилж мэдэгдсэн байна.

2. Хөдөлмөрийн байцаагчид ажил үүргээ гүйцэтгэхэд саад учруулна гэж үзэхээс бусад тохиолдолд хяналт хийхээр очих үедээ ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчид мэдэгдэнэ.

13 дугаар зүйл

1. Хөдөлмөрийн байцаагч нь үйлдвэрийн тоног төхөөрөмж, зохион байгуулалт, ажлын арга барилд илэрсэн, ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй гэж үндэслэлтэйгээр үзсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах бүрэн эрхтэй.

2. Хөдөлмөрийн байцаагчид дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх боломж олгох зорилгоор хуульд заасан шүүхийн болон захиргааны байгууллагад гомдол гаргах эрхийг нь хөндөхгүйгээр дараах шаардлагыг тавих, эсхүл тавиулах бүрэн эрх олгоно:

a) ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийн шаардлагыг хангах зорилгоор тоног төхөөрөмжийн суурилуулалт, барилга байгууламжид шаардлагатай өөрчлөлт хийж тогтоосон хугацаанд хэрэгжүүлэхийг шаардах;

b) ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд шууд, ноцтой аюул учирч болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэн даруй, заавал биелүүлэх арга хэмжээ авахыг шаардах.

3. Энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасан журам нь гишүүн улсын захиргааны болон шүүхийн практикт нийцэхгүй тохиолдолд хөдөлмөрийн байцаагч нь эрх бүхий байгууллагад шийдвэр гаргах, эсхүл нэн даруй, заавал биелүүлэх арга хэмжээ авахыг эхлүүлэх хүсэлт гаргах эрхтэй.

14 дүгээр зүйл

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг үндэсний хууль тогтоомжид заасан тохиолдол, хэлбэрийн дагуу хөдөлмөрийн хяналтын байгууллагад мэдэгдэнэ.

15 дугаар зүйл

Үндэсний хууль тогтоомж, дүрэм журмаар тогтоосон үл хамаарах нөхцөлөөс бусад тохиолдолд хөдөлмөрийн байцаагч нь:

a) шалгаж буй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд шууд болон шууд бус байдлаар ашиг сонирхлын оролцоотой байхыг хориглоно;

b) ажил үүргээ гүйцэтгэх явцад мэдсэн үйлдвэрлэлийн болон арилжааны нууц, үйлдвэрлэлийн явцтай холбоотой мэдээллийг албан тушаалаасаа чөлөөлөгдсөний дараа ч задруулахгүй байх үүрэгтэй бөгөөд үүргээ зөрчсөн тохиолдолд хуульд заасан сахилгын болон бусад хариуцлага хүлээнэ;

c) хууль тогтоомжийн зөрчил, дутагдлын талаар мэдээлсэн гомдол, мэдээллийн эх сурвалжийг чандлан нууцлах бөгөөд тухайн гомдол, мэдээллийг үндэслэн хяналт шалгалт хийснээ ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчид мэдэгдэхгүй.

16 дугаар зүйл

Холбогдох хууль тогтоомжийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах зорилгоор ажлын байранд шаардлагатай давтамж, хамрах хүрээ, нарийвчилсан байдлаар хяналт шалгалт хийнэ.

17 дугаар зүйл

1. Хөдөлмөрийн байцаагчийн хэрэгжилтэд нь хяналт тавьдаг хууль тогтоомжийг зөрчсөн, эсхүл дагаж мөрдөхөөс зайлсхийсэн хүмүүст урьдчилж мэдэгдэхгүйгээр хуулийн дагуу арга хэмжээ авч болно. Гэхдээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, эсхүл илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зорилгоор холбогдох этгээдэд урьдчилж мэдэгдсэний үндсэн дээр арга хэмжээ авах нөхцөл, журмыг үндэсний хууль тогтоомжоор тогтоож болно.

2. Хөдөлмөрийн байцаагч нь хуульд заасан арга хэмжээ авах, эсхүл тийм арга хэмжээ авахыг санал болгохын оронд сануулга, зөвлөгөө өгөх эсэхээ өөрөө шийднэ.

18 дугаар зүйл

Хөдөлмөрийн байцаагчийн хэрэгжилтэд нь хяналт тавьдаг хууль тогтоомжийг зөрчсөн, байцаагчийг албан үүргээ хэрэгжүүлэхэд нь саад учруулсан этгээдэд оногдуулбал зохих шийтгэл, хариуцлагыг үндэсний хууль тогтоомжоор тогтоож, үр дүнтэй хэрэгжүүлнэ.

19 дүгээр зүйл

1. Хөдөлмөрийн байцаагч, эсхүл орон нутгийн хяналтын алба нь үйл ажиллагааныхаа үр дүнгийн тайланг тогтмол гаргаж, хяналтын төв байгууллагад хүргүүлнэ.

2. Энэ тайланг төв байгууллагаас гаргасан маягтын дагуу, тодорхой асуудлаар тодорхой давтамжтайгаар бэлтгэнэ. Тайланг хяналтын төв байгууллагаас шаардсан хугацаанд гаргаж өгөх бөгөөд жилд нэгээс доошгүй удаа хүргүүлнэ.

20 дугаар зүйл

1. Хяналтын төв байгууллага нь өөрийн эрхлэх ажлын хүрээнд гүйцэтгэж байгаа хяналтын асуудлаар жилийн тайлан хэвлэнэ.

2. Жилийн тайланг тухайн тайлант жилийн эцсээс хойш боломжит богино хугацаанд хэвлэх бөгөөд ямар ч тохиолдолд арван хоёр сарын дотор нийтэлж хэвлүүлнэ.

3. Нийтэлж хэвлүүлсэн жилийн тайлангийн хувийг Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захиралд хүргүүлэх бөгөөд ямар ч тохиолдолд тайлан гарснаас хойш гурван сарын дотор хүргүүлсэн байна.

21 дүгээр зүйл

Хяналтын төв байгууллагын жилийн тайланд тус байгууллагаас хэрэгжүүлж буй хяналтад хамаарах дараах болон бусад холбогдох асуудлуудыг тусгана:

a) хөдөлмөрийн хяналтад хамаарах хууль тогтоомж;
b) хөдөлмөрийн хяналт гүйцэтгэх албан хаагчдын бүрэлдэхүүн;
c) хөдөлмөрийн хяналтад хамрагдах ажлын байр, ажилтны тоо;
d) хяналт хийсэн статистик мэдээ;
e) зөрчил, ногдуулсан шийтгэлийн статистик;
f) үйлдвэрлэлийн ослын статистик;
g) мэргэжлээс шалтгаалсан өвчний статистик.

II ХЭСЭГ

ХУДАЛДААНЫ САЛБАР ДАХЬ ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТ

22 дугаар зүйл

Энэхүү конвенц хүчин төгөлдөр үйлчилж буй Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн бүр худалдааны салбартаа хөдөлмөрийн хяналтын тогтолцоог бүрдүүлж, хэвийн ажиллагааг хангана.

23 дугаар зүйл

Худалдааны салбарт хөдөлмөрийн хяналтын тогтолцоо нь хөдөлмөрийн байцаагчийн хэрэгжилтэд нь хяналт тавьдаг хөдөлмөрийн нөхцөл болон ажил эрхэлж байгаа ажилтны хамгаалалтай холбоотой хууль тогтоомжийн зохицуулалт үйлчлэх бүх ажлын байранд хамаарна.

24 дүгээр зүйл

Худалдааны салбарт хөдөлмөрийн хяналтын тогтолцоо нь энэхүү конвенцын 3-21 дүгээр зүйлд заасан шаардлагуудыг хангаж, тэдгээрт нийцсэн байна.

III БУСАД ЗААЛТ

25 дугаар зүйл

1. Энэхүү конвенцыг соёрхон баталсан Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн энэхүү конвенцын II хэсгийг мөрдлөг болгохгүй тухай мэдэгдлийг батламж жуух бичигтээ тусгаж болно.

2. Ийм мэдэгдэл гаргасан аливаа гишүүн өмнө нь гаргасан шийдвэрээ дараагийн мэдэгдлээрээ ямар ч үед өөрчилж болно.

3. Энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу гаргасан мэдэгдэл нь хүчин төгөлдөр үйлчилж буй гишүүн нь конвенцын хэрэгжилтийн талаарх ээлжит илтгэлдээ энэхүү конвенцын II хэсгийн заалтад хамаарах хууль тогтоомж, практик ажлынхаа тухай, түүнчлэн уг заалт ямар хэмжээнд хэрэгжиж байгаа, эсхүл хэрхэн хэрэгжүүлэх гэж буй тухайгаа тусгана.

26 дугаар зүйл

Аль нэг аж ахуйн нэгж, түүний хэсэг, үйлчилгээ, эсхүл ажлын байр нь энэхүү конвенцын үйлчлэх хүрээнд хамаарах эсэх нь эргэлзээтэй тохиолдолд уг асуудлыг эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.

27 дугаар зүйл

Энэхүү конвенцын зорилгоор ***хууль тогтоомж*** гэсэн нэр томьёонд хууль, дүрэм, журмаас гадна хуулийн хүчинтэйд тооцогдож, хөдөлмөрийн

хяналтын байцаагчийн хэрэгжилтийг хангах бүрэн эрхэд хамаарах арбитрын шийдвэр болон хамтын гэрээг хамруулан ойлгоно.

28 дугаар зүйл

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрмийн 22 дугаар зүйлийн дагуу гаргах жилийн тайланд энэхүү конвенцын заалтыг хэрэгжүүлж буй бүх хууль тогтоомжийн талаарх бүрэн мэдээллийг багтаана.

29 дүгээр зүйл

1. Хүн амын нягтрал, газар нутгийн хөгжлийн түвшнээс шалтгаалан энэхүү конвенцыг хэрэгжүүлэх тохиромжгүй гэж гишүүн улсын эрх бүхий байгууллага үзсэн тохиолдолд тухайн нутаг дэвсгэрийг бүхэлд нь эсхүл эрх бүхий байгууллагын тохиромжтой гэж үзсэн аж ахуйн нэгж, байгууллага, эсхүл мэргэжлийг хамааруулан бусад аж ахуйн нэгж, байгууллага эсхүл мэргэжлийг хамааруулан бусад аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийг энэхүү конвенцын үйлчлэх хүрээнээс чөлөөлж болно.

2. Гишүүн бүр Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрмийн 22 дугаар зүйлийн дагуу гаргах энэхүү конвенцын хэрэгжилтийн тухай анхны тайландаа энэхүү зүйлийн заалтыг хэрэгжүүлэх гэж буй аливаа нутгийг зааж, эдгээр заалтыг хэрэглэх гэж буй шалтгааныг дурдана. Аль ч гишүүн анхны тайлангаа ирүүлснээс хойш тайланд заасан газар нутгаас өөр газар нутагт энэхүү зүйлийн заалтыг хэрэглэж болохгүй.

3. Энэхүү зүйлийн заалтыг хэрэглэж буй гишүүн бүр дараа дараагийн жилийн тайландаа энэхүү зүйлийн заалтыг хэрэглэх эрхээсээ татгалзаж буй газар нутгийг заана.

30 дугаар зүйл

1. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1946 оны шийдвэрийн дагуу өөрчилсөн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дүрмийн 35 дугаар зүйлийн 4 болон 5 дахь хэсэгт дурдсан нутаг дэвсгэрээс бусад тэрхүү зүйлд дурдсан нутаг дэвсгэрийн хувьд энэхүү конвенцыг соёрхон баталсан гишүүн түүний соёрхон баталсны дараа аль болох богино хугацаанд дор дурдсан мэдэгдлийг Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захиралд хүргүүлнэ:

(а) Конвенцын заалтыг өөрчлөлтгүйгээр хэрэглэх үүрэг хүлээж буй нутаг дэвсгэр;

(b) Конвенцын заалтыг ямар нэг өөрчлөлттэй хэрэглэхээр үүрэг хүлээж буй нутаг дэвсгэр тэдгээр өөрчлөлтийн дэлгэрэнгүйн хамт;

(c) Конвенцыг хэрэглэхгүй нутаг дэвсгэр энэ тохиолдолд конвенцыг хэрэглэхгүй болсон үндэслэл;

(d) Шийдвэр хэрхэн гаргахаа азнаж буй нутаг дэвсгэр.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн (a), (b) хэсэгт дурдсан үүрэг нь соёрхон баталсан баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд соёрхон баталсантай адил хүчинтэй байна.

3. Аливаа гишүүн дараагийн мэдэгдэл гаргах замаар энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн (b), (c), эсхүл (d) дэд хэсгийн дагуу анхны мэдэгдлээр хийсэн аливаа тайлбарыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцалж болно.

4. Аливаа гишүүн энэхүү конвенцын 34 дүгээр зүйлийн дагуу энэхүү конвенцыг цуцалж болох хугацаанд урьдах аливаа мэдэгдлийнхээ нөхцөлийг өөрчилж, тодорхой нутаг дэвсгэрт үйлчлэх нөхцөлийн талаар шинэ мэдэгдлийг Ерөнхий захиралд хүргүүлнэ.

31 дүгээр зүйл

1. Бүрэлдэхүүнд нь багтдаг боловч энэхүү конвенцод хамрагдаж буй асуудал өөрийнх нь шууд эрх мэдэлд багтах нутаг дэвсгэрийн засаг захиргаатай тохиролцсоны дагуу түүний олон улсын харилцааг хариуцдаг гишүүн нь тухайн нутаг дэвсгэрийн нэрийн өмнөөс энэхүү конвенцын дагуу үүрэг хүлээх тухай мэдэгдлийг Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захиралд хүргүүлнэ.

2.Энэхүү конвенцын дагуу үүрэг хүлээх тухай мэдэгдлийг Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захиралд:

(a) Байгууллагын хоёр, эсхүл түүнээс дээш гишүүн тэдгээрийн хамтын удирдлагад оршдог нутаг дэвсгэртэй холбогдуулж;

(b) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн дагуу, эсхүл өөр байдлаар аливаа нутаг дэвсгэрийг удирдах хариуцлага хүлээдэг олон улсын эрх бүхий аливаа байууллага уг нутаг дэвсгэртэй холбогдуулж хүргүүлнэ.

3. Энэхүү зүйлийн өмнөх хэсгийн дагуу Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захиралд илгээсэн мэдэгдэлд конвенцын заалтыг тухайн нутаг дэвсгэрт өөрчлөлтгүйгээр, эсхүл өөр хэрэглэх талаар заана. Хэрэв конвенцын заалтыг өөрчилж хэрэглэхээр мэдэгдэлд заасан бол тэдгээр өөрчлөлтийг нарийвчлан заана.

4. Холбогдох гишүүн, гишүүд, эсхүл олон улсын эрх бүхий байгууллага урьд гаргасан мэдэгдэлдээ заасан аливаа өөрчлөлтийг хэрэглэх эрхээсээ дараагийн мэдэгдэл гаргах замаар бүхэлд нь, **эсхүл** хэсэгчлэн хэдийд ч татгалзаж болно.

5. Конвенцын 34 дүгээр зүйлд заасны дагуу энэхүү конвенцыг цуцалж болох аль ч үед холбогдох гишүүн, гишүүд, эсхүл олон улсын эрх бүхий байгууллага аливаа өмнөх мэдэгдлийн нөхцөлийг аливаа бусад байдлаар өөрчилсөн бөгөөд энэхүү конвенцын хэрэгжилтийн байдлыг мэдээлсэн мэдэгдлийг Ерөнхий захиралд хүргүүлнэ.

IV. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

32 дугаар зүйл

Энэхүү конвенцыг албан ёсоор соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захиралд бүртгүүлэхээр хүргүүлнэ.

33 дугаар зүйл

1. Энэхүү конвенцыг соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг Ерөнхий захиралд бүртгүүлсэн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн заавал биелүүлэх үүрэг хүлээнэ.

2. Хоёр гишүүний соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг Ерөнхий захирал бүртгэсэн өдрөөс хойш арван хоёр сарын дараа энэхүү конвенц хүчин төгөлдөр болно.

3. Түүнээс хойш энэхүү конвенц аливаа гишүүн улсын хувьд соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг бүртгүүлсэн өдрөөс хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

34 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцыг соёрхон баталсан аливаа гишүүн түүнийг анх хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш арван жилийн дараа конвенцыг цуцлах тухай хүсэлтээ Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захиралд илгээн бүртгүүлснээр конвенцыг цуцалж болно. Цуцлалт нь тухайн хүсэлтийг бүртгэснээс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү конвенцыг соёрхон баталсан гишүүн бүр өмнөх хэсэгт дурдсан арван жилийн хугацаа дууссанаас хойш нэг жилийн дотор конвенцыг

цуцлах тухай энэхүү зүйлд заасан эрхийг хэрэгжүүлээгүй тохиолдолд дараагийн арван жилийн хугацаанд уг конвенцыг дагаж мөрдөх бөгөөд түүнээс хойш арван жилийн хугацаа өнгөрөх бүрд энэхүү зүйлд заасан нөхцөлийн дагуу энэхүү конвенцыг цуцалж болно.

35 дугаар зүйл

1. Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захирал нь гишүүн улс энэхүү конвенцыг соёрхон баталсан, эсхүл цуцалсан тухайг бүртгэснээ Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын бүх гишүүдэд мэдээлнэ.

2. Ерөнхий захирал энэхүү конвенцыг хоёр дахь удаагаа соёрхон баталсан тухай гишүүн улсын мэдэгдлийг бүртгэж, конвенц хүчин төгөлдөр болох хугацааг гишүүдэд мэдэгдэнэ.

36 дугаар зүйл

Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захирал энэхүү конвенцыг өмнөх зүйлд заасны дагуу соёрхон баталсан тухай болон мэдэгдэл, цуцлалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бүртгүүлэхээр хүргүүлнэ.

37 дугаар зүйл

Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Захиргааны зөвлөл шаардлагатай гэж үзвэл энэхүү конвенцыг хэрхэн хэрэгжүүлж буй тухай Ерөнхий бага хуралд тайлагнах бөгөөд түүнийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь хянан өөрчлөх тухай асуудлыг Бага хурлаар хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

38 дугаар зүйл

1. Бага хурлаар энэхүү конвенцыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хянаж өөрчилж баталсан тохиолдолд, шинэ конвенц өөрөөр заагаагүй бол:

a) Гишүүн улс хянаж өөрчилсөн конвенцыг соёрхон баталснаар шинэ конвенц хүчин төгөлдөр болох бөгөөд энэхүү конвенцын 34 дүгээр зүйлийн заалтыг үл харгалзан энэхүү конвенц эрх зүйн хувьд автоматаар даруй хүчингүй болно;

b) Хянаж өөрчилсөн шинэ конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш энэхүү конвенцыг гишүүд соёрхон батлах явдал дуусгавар болно.

2. Энэхүү конвенцыг соёрхон баталсан боловч хянаж өөрчилсөн шинэ конвенцыг соёрхон батлаагүй гишүүний хувьд энэхүү конвенц нь хэлбэр, агуулгаараа аль ч тохиолдолд хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

39 дүгээр зүйл

Энэхүү конвенцын англи, франц хэлээр үйлдсэн эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦ №129 ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТЫН КОНВЕНЦ (ХӨДӨӨ АЖ АХУЙ), 1969

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ерөнхий Бага Хурал нь,

Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Удирдах Зөвлөлөөс 1969 оны 6 дугаар сарын 4-нд Женев хотноо зарлан хуралдуулсан тавин гурав дахь удаагийн чуулганаараа,

Өмнө баталсан Хөдөлмөрийн хяналтын тухай олон улсын конвенцуудыг, тухайлбал аж үйлдвэр, худалдааны салбарт хамаарах Хөдөлмөрийн хяналтын тухай 1947 оны конвенц, хөдөө аж ахуйн зарим үйлдвэрлэлд хамаарах Тариалангийн тухай 1958 оны конвенцын заалтуудыг үндэслэн,

Хөдөө аж ахуйн хөдөлмөрийн хяналтын олон улсын хэм хэмжээг нийтээр хүлээн зөвшөөрүүлэхийг зорьж,

Чуулганы хэлэлцэх хэргийн дөрөв дэх асуудал болох хөдөө аж ахуйн хөдөлмөрийн хяналтын тухай тодорхой саналуудыг батлахаар шийдвэрлэж,

Эдгээр саналыг олон улсын конвенцын хэлбэрээр хүлээж авахаар шийдвэрлэж,

Нэг мянга есөн зуун жаран есөн оны зургаадугаар сарын хорин тавны энэ өдөр дараах конвенцыг Хөдөлмөрийн хяналтын тухай 1969 оны конвенц (хөдөө аж ахуй) хэмээн нэрлэхээр тогтож батлав.

1 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцод ***хөдөө аж ахуйн нэгж*** гэсэн нэр томьёог газар тариалан, мал аж ахуй, тухайлбал, мал маллагаа, мал үржүүлэг, ойн аж ахуй, цэцэрлэгжүүлэлт, тухайн аж ахуйн нэгжийн гүйцэтгэж байгаа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалт, хөдөө аж ахуйн үйл ажиллагааны бусад хэлбэрийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, эсхүл түүний хэсэг гэж ойлгоно.

2. Эрх бүхий байгууллага нь шаардлагатай тохиолдолд, хэрвээ байгаа бол, ажил олгогч, ажилтны хамгийн төлөөлөх чадвартай байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр хөдөө аж ахуйг аж үйлдвэр, худалдаанаас зааглах шалгуурыг тогтоох бөгөөд ингэхдээ хөдөө аж ахуйн ямар ч аж ахуйн нэгжийг хөдөлмөрийн хяналтын үндэсний тогтолцооны гадуур орхигдохгүй байхаар тодорхойлно.

3. Аж ахуйн нэгж, түүний хэсэг нь энэхүү конвенцын үйлчлэх хүрээнд хамаарах эсэх нь эргэлзээтэй тохиолдолд уг асуудлыг эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.

2 дугаар зүйл

Энэхүү конвенцын зорилгоор ***хууль тогтоомж*** гэсэн нэр томьёонд хууль, дүрэм, журмаас гадна хуулийн хүчинтэйд тооцогдож, хөдөлмөрийн хяналтын байцаагчийн хэрэгжилтийг хангах бүрэн эрхэд хамаарах арбитрын шийдвэр, хамтын гэрээг хамруулан ойлгоно.

3 дугаар зүйл

Энэхүү конвенц хүчин төгөлдөр үйлчилж буй Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн бүр хөдөө аж ахуйн салбартаа хөдөлмөрийн хяналтын тогтолцоог бий болгож, хэвийн ажиллагааг хангана.

4 дүгээр зүйл

Хөдөө аж ахуйн хөдөлмөрийн хяналтын тогтолцоо нь хөдөө аж ахуйн салбарт ажилладаг нийт хүмүүс, дагалдан суралцагсад хамаарах бөгөөд тэд цалин хөлсөөр ажиллаж, тэдний гэрээний төрөл, хэлбэр, хугацаа янз бүр байж болно.

5 дугаар зүйл

1. Гишүүн улс нь конвенцыг соёрхон баталж буй тухай мэдэгдэлдээ хөдөө аж ахуйн хөдөлмөрийн хяналтад хөдөө аж ахуйн нэгжид ажиллаж буй дараах хүмүүсийг конвенцын үйлчлэлд хамруулах тухайгаа тэмдэглэж болно. Үүнд:

a) Бусдыг ажиллуулдаггүй түрээслэгч, ургац хуваан ашиглагч, түүнтэй ижил төрлийн хөдөө аж ахуйн бусад ажиллагсад;
b) Хоршооны гишүүн гэх мэт хамтын тооцоотой аж ахуйн нэгжид ажиллагсад;
c) Үндэсний хууль тогтоомжид заасны дагуу аж ахуй эрхлэгчийн гэр бүлийн гишүүд.

2. Конвенцыг соёрхон баталсан гишүүн улс нь дээр дурдсан ажиллагсдыг тусгайлан зааж хамруулаагүй бөгөөд нэг ба түүнээс олон тооны бүлгийн ажиллагсдыг нэмж хамруулах бол энэ тухай мэдэгдлээ Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захиралд дараа нь хүргүүлж болно.

3. Конвенцыг соёрхон баталсан гишүүн улс нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Дүрмийн хорин хоёрдугаар зүйлд нийцүүлэн гаргадаг

тайландаа уг конвенцыг баталсан тухай мэдэгдэлдээ заагаагүй нэгдүгээр хэсэгт дурдсан ажиллагчдын хувьд энэхүү конвенцын заалтуудыг хэрхэн хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа тухайгаа тодорхой тусгана.

6 дугаар зүйл

1. Хөдөө аж ахуйн хөдөлмөрийн хяналтын тогтолцооны чиг үүрэг нь:

a) Цаг, цалин хөлс, долоо хоногийн амралт, баярын өдрүүд, аюулгүй байдал, эрүүл мэнд, ахуй хангамж, эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудын хөдөлмөр эрхлэлт болон бусад холбогдох асуудлаар хөдөлмөрийн байцаагч ажилтныг ажил үүргээ гүйцэтгэж байх үед нь хамгаалах, хөдөлмөрийн нөхцөлийг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хөдөлмөрийн байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хангах;

b) Ажил олгогч, ажилтан хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд хамгийн үр дүнтэй арга замын талаар мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл хуваалцах;

c) Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжоор тусгайлан зохицуулаагүй зөрчил, дутагдлыг холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэж, хууль тогтоомжийг сайжруулах санал хүргүүлэх.

2. Ажилтан, түүний гэр бүлийн гишүүдийн амьдралын нөхцөлтэй холбоотой хууль тогтоомжийг мөрдүүлэх, заавар зөвлөгөө өгөх чиг үүргийг хөдөө аж ахуйн хөдөлмөрийн байцаагчид үндэсний хууль тогтоомжоор олгож болно.

3. Хөдөө аж ахуйн хөдөлмөрийн байцаагчид нэмэлт чиг үүрэг хариуцуулж болох боловч тийм чиг үүрэг нь түүний үндсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд саад учруулахгүй, ажил олгогч, ажилтантай харилцахад шаардлагатай эрх мэдэл, хараат бус, төвийг сахисан байдлыг нь алдагдуулахгүй байна.

7 дугаар зүйл

1. Хөдөө аж ахуйд хөдөлмөрийн хяналтыг гишүүн улсын төрийн захиргааны байгууллагын тогтолцоонд нийцүүлэн төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, хяналтад хэрэгжүүлнэ.

2. Холбооны зохион байгуулалттай улсын хувьд ***төв байгууллага*** гэдэг нь нэг бол холбооны дээд удирдлага, эсхүл холбооны аль нэг захиргааны төв байгууллага байж болно.

3. Хөдөө аж ахуйн хөдөлмөрийн хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлж болно:

a) эдийн засгийн үйл ажиллагааны бүх салбарыг бүхэлд нь хариуцсан хөдөлмөрийн хяналтын нэгжээр дамжуулах;
b) хөдөө аж ахуйн салбарт хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх хөдөлмөрийн байцаагчдыг зохих сургалтад хамруулах замаар дотоод чиг үүргийн мэргэшлийг бий болгосон хөдөлмөрийн хяналтын нэгжээр дамжуулах;
c) нэгж дотооддоо хөдөө аж ахуйн салбарт хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх техникийн өндөр ур чадвар бүхий хөдөлмөрийн байцаагчдаас бүрдсэн мэргэшлийн алба байгуулах; эсхүл
d) аж үйлдвэр, тээвэр, худалдаа зэрэг бусад салбарын хөдөлмөрийн хяналтыг хариуцсан, төв байгууллагын удирдлага, хяналтад ажилладаг албад шиг хөдөө аж ахуйн мэргэшсэн хөдөлмөрийн хяналтын алба байгуулж хэрэгжүүлэх.

8 дугаар зүйл

1. Хөдөө аж ахуйн хөдөлмөрийн байцаагч нь төрийн албан хаагч байх бөгөөд тэдний эрх зүйн байдал, ажлын нөхцөл нь ажлын байрандаа тогтвортой ажиллах байдлыг баталгаажуулж, Засгийн газар өөрчлөгдөх, эсхүл гаднын зохисгүй нөлөөнөөс хараат бус байх баталгааг бүрдүүлсэн байна.

2. Гишүүн улс нь үндэсний хууль тогтоомж, практикт нийцэж байгаа тохиолдолд төрийн хяналтын байцаагчийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор хөдөө аж ахуйн хөдөлмөрийн хяналтын тогтолцоонд мэргэжлийн холбоодын ажилтан, төлөөлөгчийг оролцуулж болох бөгөөд тухайн ажилтан гаднын зохисгүй нөлөөнөөс хараат бус байж, түүний ажлын тогтвортой байдлыг нь хангасан байна.

9 дүгээр зүйл

1. Хөдөө аж ахуйн хөдөлмөрийн байцаагчийг ажилд авахдаа үндэсний хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчийг сонгон шалгаруулахад баримталдаг аливаа журмын хүрээнд ажил үүргээ биелүүлэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадварыг харгалзан шалгаруулна.

2. Мэргэжлийн ур чадварыг тодорхойлох журмыг эрх бүхий байгууллага тогтооно.

3. Хөдөө аж ахуйн хөдөлмөрийн байцаагч нь албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай сургалтад хангалттай хамрагдсан байх бөгөөд ажиллаж байх хугацаанд нь зохих сургалтад хамруулах арга хэмжээг авна.

10 дугаар зүйл

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс хөдөө аж ахуйн хөдөлмөрийн байцаагчаар ажиллаж болох бөгөөд шаардлагатай тохиолдолд тодорхой ажил үүргийг эрэгтэй, эмэгтэй байцаагчид тусгайлан хариуцуулж болно.

11 дүгээр зүйл

Гишүүн улс нь хөдөө аж ахуйн хөдөлмөрийн хяналтын үйл ажиллагаанд техникийн мэдлэг шаардсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж чадах зохих мэргэшил бүхий техникийн эксперт, мэргэжилтнийг үндэсний нөхцөл байдалд хамгийн тохиромжтой гэж үзсэн хэлбэрээр оролцуулах шаардлагатай арга хэмжээг авна.

12 дугаар зүйл

1. Эрх бүхий байгууллага нь хөдөө аж ахуйн хөдөлмөрийн хяналтын үйл ажиллагааг Засгийн газрын бусад байгууллага, ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн болон зөвшөөрөгдсөн байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллахыг дэмжих шаардлагатай зохицуулалтыг хийнэ.

2. Шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллага конвенцын зарчмын хэрэгжилтийг гажуудуулахгүйгээр бүс, орон нутагт гүйцэтгэх хөдөлмөрийн хяналтын тодорхой чиг үүргийг төрийн холбогдох албаа, байгууллагад нэмж хариуцуулж болох бөгөөд, эсхүл уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд эдгээр албаа, байгууллагын оролцоог хангаж болно.

13 дугаар зүйл

Эрх бүхий байгууллага нь хөдөө аж ахуйн хөдөлмөрийн байцаагч болон ажил олгогч, ажилтан, хэрэв байдаг бол, тэдгээрийн төлөөллийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр шаардлагатай зохицуулалтыг хийнэ.

14 дүгээр зүйл

Хөдөө аж ахуйд хөдөлмөрийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дор дурдсан нөхцөлийг харгалзаж үзсэний үндсэн дээр хүрэлцэхүйц тооны хөдөлмөрийн байцаагчийг томилох арга хэмжээг авна:

а) байцаагчийн хэрэгжүүлэх чиг үүргийн цар хүрээ, ач холбогдол, ялангуяа:

i. хяналт шалгалтад хамрагдах хөдөө аж ахуйн аж ахуйн нэгжийн тоо төрөл, хэмжээ, байршил;

ii. аж ахуйн нэгжид ажиллаж байгаа хүмүүсийн тоо, ангилал;
iii. хэрэгжилтийг хангах хууль тогтоомжийн тоо, төвөгшил.

b) байцаагчийн үйл ажиллагаанд зориулан олгосон материаллаг нөөц бололцоо;
c) хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор байцаагч газар дээр нь заавал очиж шалгах бодит нөхцөл байдал.

15 дугаар зүйл

1. Эрх бүхий байгууллага нь хөдөлмөрийн байцаагчийг дор дурдсан нөхцөлөөр хангахад шаардлагатай арга хэмжээ авна:
a) хөдөө аж ахуйн аж ахуйн нэгжийн газар зүйн байрлал, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай холбоо харилцааны арга хэрэгслийг харгалзан байршил бүхий бүх хүнд хүртээмжтэй ажлын байр;
b) тохиромжтой нийтийн тээврийн хэрэгсэл байхгүй тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тээврийн хэрэгсэл.

2. Эрх бүхий байгууллага нь хөдөлмөрийн байцаагчийг албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан томилолтын болон бусад зардлыг нөхөн олгох шаардлагатай арга хэмжээг авна.

16 дугаар зүйл

1. Бүрэн эрхийг нь нотлох бичиг баримт бүхий хөдөлмөрийн байцаагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
a) хяналт шалгалтад хамрагдах аливаа ажлын байранд өдөр, шөнийн аль ч цагт урьдчилан мэдэгдэлгүйгээр чөлөөтэй нэвтрэн орох;
b) хяналт шалгалтад хамрагдах үндэслэлтэй гэж үзсэн аливаа байр, байгууламжид өдрийн цагаар нэвтрэн орох;
c) хууль тогтоомж хэрэгжиж байгааг бүрэн тогтоох зорилгоор шаардлагатай гэж үзсэн аливаа үзлэг, шалгалт, туршилт, судалгааг явуулж болох бөгөөд тухайлбал,
i. хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой аливаа асуудлаар, ажил олгогч, эсхүл байгууллагын ажилтнаас гэрчийг байлцуулан, эсхүл байлцуулахгүйгээр тайлбар, мэдүүлэг авах;
ii. амьдралын нөхцөл, хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотойгоор хууль тогтоомжид заасан бүртгэл, данс тооцоо, баримт бичиг болон бусад материалыг хууль тогтоомжид заасан бол тийм байдлаар

гаргуулан авч, хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгах, тэдгээрээс хуулбарлах, хэсэгчлэн авах;

iii. шинжилгээ хийх зорилгоор ашиглаж, хэрэглэж байгаа материал, бодисоос дээж авах, хураах бөгөөд ямар зорилгоор дээж авах, эсхүл хурааж байгаа тухайгаа ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчид урьдчилж мэдэгдсэн байна.

2. Хөдөлмөрийн байцаагч нь энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн (a), (b) заалтыг хэрэгжүүлэх зорилгоор аж ахуй эрхлэгчийн хувийн сууцанд нэвтэрч болохгүй бөгөөд зөвхөн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, эсхүл аж ахуй эрхлэгчийн зөвшөөрлийн дагуу нэвтэрнэ.

3. Хөдөлмөрийн байцаагчид ажил үүргээ гүйцэтгэхэд саад учруулна гэж үзэхээс бусад тохиолдолд хяналт хийхээр очих үедээ ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгч, ажилтан, түүний төлөөлөгчид мэдэгдэнэ.

17 дугаар зүйл

Эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй шинэ ургамал, шинэ материал, бодис, эсхүл бүтээгдэхүүнтэй харьцах, боловсруулах шинэ арга ажиллагаанд гүйцэтгэх урьдчилан сэргийлэх хяналтад хөдөө аж ахуйн хөдөлмөрийн хяналтыг эрх бүхий байгууллагаас тодорхойлсон тохиолдол, арга барилыг ашиглан оролцуулж болно.

18 дугаар зүйл

1. Хөдөө аж ахуйн хөдөлмөрийн байцаагч нь хөдөө аж ахуйн аж ахуйн нэгжид аюултай материал, бодис ашиглах болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, зохион байгуулалт, ажлын арга барилд илэрсэн, эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй гэж үзсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах бүрэн эрхтэй.

2. Хөдөлмөрийн байцаагчид дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх боломж олгох зорилгоор хуульд заасан шүүхийн болон захиргааны байгууллагад гомдол гаргах эрхийг нь хөндөхгүйгээр дараах шаардлагыг тавих, эсхүл тавиулах бүрэн эрх олгоно:

а) ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийн шаардлагыг хангах зорилгоор тоног төхөөрөмжийн суурилуулалт, барилга байгууламж, ажлын байр, машин механизм, тоног төхөөрөмжид шаардлагатай өөрчлөлт хийж, тогтоосон хугацаанд хэрэгжүүлэхийг шаардах;

b) эрүүл мэнд, аюулгүй байдалд шууд, ноцтой аюул учирч болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд ажлыг зогсоох хүртэл нэн даруй, заавал биелүүлэх арга хэмжээ авахыг шаардах.

3. Энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасан журам нь гишүүн улсын захиргааны болон шүүхийн практикт нийцэхгүй тохиолдолд хөдөлмөрийн байцаагч нь эрх бүхий байгууллагад шийдвэр гаргах, эсхүл нэн даруй, заавал биелүүлэх арга хэмжээ авахыг эхлүүлэх хүсэлт гаргах эрхтэй.

4. Байцаагч нь аж ахуйн нэгжид хийсэн шалгалтын явцад илрүүлсэн зөрчил, дутагдал, энэхүү зүйлийн 2 дахь хэсгийн дагуу гаргаж байгаа, эсхүл гаргуулсан шийдвэр, эсхүл 3 дахь хэсэгт заасны дагуу гаргуулахаар хүсэж буй шийдвэрийг ажил олгогч болон ажилтны төлөөлөлд мэдэгдэнэ.

19 дүгээр зүйл

1. Хөдөө аж ахуйн салбарт гарсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг үндэсний хууль тогтоомжид заасан тохиолдол, хэлбэрийн дагуу хөдөө аж ахуйн хөдөлмөрийн хяналтын байгууллагад мэдэгдэнэ.

2. Олон тооны ажилтныг хамарсан, эсхүл хүний амь нас хохирсон үйлдвэрлэлийн ноцтой осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний учир шалтгааныг газар дээр нь шалган тогтоох ажиллагаанд хөдөө аж ахуйн салбарт хяналт хийж буй хөдөлмөрийн байцаагчийг аль болох оролцуулна.

20 дугаар зүйл

Үндэсний хууль тогтоомжоор тогтоосон үл хамаарах нөхцөлөөс бусад тохиолдолд хөдөө аж ахуйн хөдөлмөрийн байцаагч нь:

a) шалгаж буй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд шууд болон шууд бус байдлаар ашиг сонирхлын оролцоотой байхыг хориглоно;

b) ажил үүргээ гүйцэтгэх явцад мэдсэн үйлдвэрлэлийн болон арилжааны нууц, үйлдвэрлэлийн явцтай холбоотой мэдээллийг албан тушаалаасаа чөлөөлөгдсөний дараа ч задруулахгүй байх үүрэгтэй бөгөөд үүргээ зөрчсөн тохиолдолд хуульд заасан сахилгын болон бусад хариуцлага хүлээнэ;

c) зөрчил, дутагдал, үйлдвэрлэлийн явцад үүссэн аюултай нөхцөл байдал, хууль тогтоомжийн зүйл, заалтыг зөрчиж буй талаар мэдээлсэн гомдол, мэдээллийн эх сурвалжийг чандлан нууцлах бөгөөд тухайн гомдол, мэдээллийг үндэслэн хяналт шалгалт хийснээ ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчид мэдэгдэхгүй.

21 дүгээр зүйл

Холбогдох хууль тогтоомжийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах зорилгоор хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй аж ахуйн нэгжид шаардлагатай давтамж, хамрах хүрээ, нарийвчилсан байдлаар хяналт шалгалт хийнэ.

22 дугаар зүйл

1. Хөдөө аж ахуйн хөдөлмөрийн байцаагчийн хэрэгжилтэд нь хяналт тавьдаг хууль тогтоомжийг зөрчсөн, эсхүл дагаж мөрдөхөөс зайлсхийсэн хүмүүст урьдчилж мэдэгдэхгүйгээр хуулийн, эсхүл захиргааны арга хэмжээ авч болно. Гэхдээ урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, эсхүл илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зорилгоор холбогдох этгээдэд урьдчилж мэдэгдсэний үндсэн дээр арга хэмжээ авах нөхцөл, журмыг үндэсний хууль тогтоомжоор тогтоож болно.

2. Хөдөлмөрийн байцаагч нь хуульд заасан арга хэмжээ авах, эсхүл тийм арга хэмжээ авахыг санал болгохын оронд сануулга, зөвлөгөө өгөх эсэхээ өөрөө шийднэ.

23 дугаар зүйл

Хөдөө аж ахуйн хөдөлмөрийн байцаагч нь хэрэг үүсгэн шалгах ажиллагааг өөрсдөө эхлүүлэх эрхгүй тохиолдолд хууль тогтоомжийн заалтыг зөрчсөн тухай илтгэлийг ийм ажиллагааг эхлүүлэх эрх бүхий байгууллагад шууд хүргүүлж шийдвэрлүүлэх эрхтэй байна.

24 дүгээр зүйл

Хөдөө аж ахуйн хөдөлмөрийн байцаагчийн хэрэгжилтэд нь хяналт тавьдаг хууль тогтоомжийг зөрчсөн, байцаагчийг албан үүргээ хэрэгжүүлэхэд нь саад учруулсан этгээдэд оногдуулбал зохих шийтгэл, хариуцлагыг үндэсний хууль тогтоомжоор тогтоож, үр дүнтэй хэрэгжүүлнэ.

25 дугаар зүйл

1. Хөдөлмөрийн байцаагч, эсхүл орон нутгийн хяналтын алба нь хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа үр дүнгийн тайланг тогтмол гаргаж, хяналтын төв байгууллагад хүргүүлнэ.

2. Энэхүү тайланг төв байгууллагаас гаргасан маягтын дагуу, тодорхой асуудлаар тодорхой давтамжтайгаар бэлтгэнэ. Тайланг хяналтын төв байгууллагаас шаардсан хугацаанд гаргаж өгөх бөгөөд жилд нэгээс доошгүй удаа хүргүүлнэ.

26 дугаар зүйл

1. Хяналтын төв байгууллага нь өөрийн эрхлэх ажлын хүрээнд гүйцэтгэж байгаа хөдөө аж ахуйн хяналтын асуудлаар тусад нь, эсхүл жилийн ерөнхий тайлангийн нэг бүлэг болгож хэвлэнэ.

2. Жилийн тайланг тухайн тайлант жилийн эцсээс хойш боломжит богино хугацаанд хэвлэх бөгөөд ямар ч тохиолдолд арван хоёр сарын дотор нийтэлж хэвлүүлнэ.

3. Нийтэлж хэвлүүлсэн жилийн тайлангийн хувийг Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захиралд хүргүүлэх бөгөөд ямар ч тохиолдолд тайлан гарснаас хойш гурван сарын дотор хүргүүлсэн байна.

27 дугаар зүйл

Хяналтын төв байгууллагын жилийн тайланд тус байгууллагаас хэрэгжүүлж буй хяналтад хамаарах дараах асуудлуудыг тусгана:

a) хөдөө аж ахуйн хөдөлмөрийн хяналтад хамаарах хууль тогтоомж;
b) хөдөө аж ахуйд хөдөлмөрийн хяналт гүйцэтгэх албан хаагчдын бүрэлдэхүүн;
c) хяналтад хамрагдвал зохих хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага, түүнд ажиллаж байгаа хүмүүсийн статистик;
d) хяналт хийсэн статистик;
e) зөрчил, ногдуулсан шийтгэлийн статистик;
f) үйлдвэрлэлийн осол, шалтгааны статистик;
g) мэргэжлээс шалтгаалсан өвчин, шалтгааны статистик.

28 дугаар зүйл

Энэхүү конвенцыг албан ёсоор соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захиралд бүртгүүлэхээр хүргүүлнэ.

29 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцыг соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг Ерөнхий захиралд бүртгүүлсний дараа Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн улс конвенцыг заавал биелүүлэх үүрэг хүлээнэ.

2. Хоёр гишүүний соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг Ерөнхий захирал бүртгэсэн өдрөөс хойш арван хоёр сарын дараа энэхүү конвенц хүчин төгөлдөр болно.

3. Түүнээс хойш энэхүү конвенц аливаа гишүүн улсын хувьд соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг бүртгүүлсэн өдрөөс хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

30 дугаар зүйл

1. Энэхүү конвенцыг соёрхон баталсан аливаа гишүүн түүнийг анх хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш арван жилийн дараа конвенцыг цуцлах тухай хүсэлтээ Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захиралд илгээн бүртгүүлснээр конвенцыг цуцалж болно. Цуцлалт нь тухайн хүсэлтийг бүртгэснээс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү конвенцыг соёрхон баталсан гишүүн бүр өмнөх хэсэгт дурдсан арван жилийн хугацаа дууссанаас хойш нэг жилийн дотор конвенцыг цуцлах тухай энэхүү зүйлд заасан эрхийг хэрэгжүүлээгүй тохиолдолд дараагийн арван жилийн хугацаанд уг конвенцыг дагаж мөрдөх бөгөөд түүнээс хойш арван жилийн хугацаа өнгөрөх бүрд энэхүү зүйлд заасан нөхцөлийн дагуу энэхүү конвенцыг цуцалж болно.

31 дүгээр зүйл

1. Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захирал нь гишүүн улс энэхүү конвенцыг соёрхон баталсан, эсхүл цуцалсан тухай бүртгэснээ Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын бүх гишүүдэд мэдээлнэ.

2. Ерөнхий захирал энэхүү конвенцыг хоёр дахь удаагаа соёрхон баталсан тухай гишүүн улсын мэдэгдлийг бүртгэж, конвенц хүчин төгөлдөр болох хугацааг гишүүдэд мэдэгдэнэ.

32 дугаар зүйл

Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Ерөнхий захирал энэхүү конвенцыг өмнөх зүйлд заасны дагуу соёрхон баталсан тухай болон мэдэгдэл, цуцлалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бүртгүүлэхээр хүргүүлнэ.

33 дугаар зүйл

Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Захиргааны Зөвлөл шаардлагатай гэж үзвэл энэхүү Конвенцыг хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай Ерөнхий чуулганд оруулж, түүнийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хянан өөрчлөх тухай асуудлыг Чуулганаар хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

34 дүгээр зүйл

1. Бага хурлаар энэхүү конвенцыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хянаж өөрчилж баталсан тохиолдолд, шинэ конвенц өөрөөр заагаагүй бол:

a) гишүүн улс хянаж өөрчилсөн конвенцыг соёрхон баталснаар шинэ конвенц хүчин төгөлдөр болох бөгөөд энэхүү конвенцын 30 дугаар зүйлийн заалтыг үл харгалзан энэхүү конвенц эрх зүйн хувьд автоматаар даруй хүчингүй болно.

b) хянаж өөрчилсөн шинэ конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш энэхүү конвенцыг гишүүд соёрхон батлах явдал дуусгавар болно.

2. Энэхүү конвенцыг соёрхон баталсан боловч хянаж өөрчилсөн шинэ конвенцыг соёрхон батлаагүй гишүүний хувьд энэхүү конвенц нь хэлбэр, агуулгаараа аль ч тохиолдолд хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

35 дугаар зүйл

Энэхүү конвенцын англи, франц хэлээр үйлдсэн эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

---o0o---

Хаяг:
“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
Утас: 262420
Хэвлэлийн хуудас: 2
Индекс: 200003